



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 448

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 1,844.7 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбууд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэлийг сайжруулах, төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авахгүй байх;

2.2. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах;

2.3. Гадаад улсаас худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд шууд гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний хувийг, уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт Сангийн яаманд хүргүүлж хэвших;

2.4. 2016-2017 онд төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсэлснээс олсон 22.4 сая төгрөгийн орлогод ногдох 6.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх;

2.5. 2018 оны төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” 102 дугаар тогтоолын дагуу байгуулах, улсын төсөвт ногдох хувийг бүрэн төвлөрүүлэх;

2.6. 2016 онд үүссэн 2 харилцагчтай холбоотой, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 37.2 сая төгрөгийн авлагын асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх;

2.7. 2008-2010 онд байгууллагын ажилчдад нийгмийн асуудал шийдвэрлэх зориулалтаар орон сууцны дэмжлэг, мөнгөн хэлбэрээр 24 ажилтанд олгосон 343.5 сая төгрөгийн балансын үнэ, 3.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл, 340.2 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий орон сууцыг данснаас хасах асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх;

2.8. Дээд шатны байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах, биелэлтийг хугацаанд нь тайлагнаж байх;

0002401

2.9. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б. ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
~~448~~ дугаар тогтоолын хавсралт

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат
компанид хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах нэгж	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн	Захиргаа, удирдлагын хэлтэс	273.30	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу үндсэн хөрөнгө олж авах
2	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зөрчил	Захиргаа, удирдлагын хэлтэс	1,070.90	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль, холбогдох журмыг мөрдөж хэрэгжүүлэх
3	Өглөг, авлагатай холбоотой зөрчил	Захиргаа, удирдлагын хэлтэс	42.10	Өглөг, авлагын тооцоо нийлэх, хууль, шүүхийн байгууллагад шилжүүлж барагдуулах арга хэмжээ авах
4	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний зөрчил	Захиргаа, удирдлагын хэлтэс	2.96	Түрээсийн гурвалсан гэрээ байгуулах, орлогын зохих хувийг Улсын төсөвт төвлөрүүлэх
2016 оны дүн:			1,389.26	
1	Зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн	Захиргаа, удирдлагын хэлтэс	164.80	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу үндсэн хөрөнгө олж авах
2	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зөрчил	Захиргаа, удирдлагын хэлтэс	286.80	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль, холбогдох журмыг мөрдөж хэрэгжүүлэх
3	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний зөрчил	Захиргаа, удирдлагын хэлтэс	3.79	Түрээсийн гурвалсан гэрээ байгуулах, орлогын зохих хувийг Улсын төсөвт төвлөрүүлэх
2017 оны дүн:			455.39	
Зөрчил, дутагдлын нийт дүн:			1,844.7	